



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/93

Хужирт сум

Хүүхдийн төлөө зөвлөл шинэчлэн  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн эрхийг хангах талаарх салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий сумын хүүхдийн төлөө зөвлөлийг хавсралтаар шинэчлэн байгуулсугай.

2. Сумын хэмжээнд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хүүхдийн эрхийн талаарх асуудлыг шийдвэрлэх, хүүхдийн оролцооны байгууллагыг дэмжиж ажиллахыг ажлын хэсэг, нарийн бичгийн дарга (Д.Давга)-д тус тус даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн "Хүүхдийн төлөө зөвлөл шинэчлэн байгуулах тухай" А/88 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.БАТБАЯР



622401065

D:Alban bichig;Zahiramj 2024